



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/440

Булган сум

Хорих ангийн эмнэлэгт дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Булган аймаг дахь 439 дүгээр хаалттай хорих ангийн эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдлуудад анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмж авахад нь зориулж 15,000,000 (арван таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрхи хөрөнгийг Засаг даргын хуулиар хүлээсэн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



0303010458